

АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

2022.12.09

Алтай хот

Аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр хяналт-шинжилгээ хийж, дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний 74 арга хэмжээний 44 нь 100 хувь, 6 нь 90 хувь, 16 нь 70 хувь, 6 нь 50 хувь, 2 нь 30 хувьтай үнэлэгдлээ.

2. "Эрчимжүүлэх шаардлагатай" 8 арга хэмжээ байгаа бөгөөд эдгээрийн 7 нь хөрөнгө, санхүүгийн асуудлаас, 1 нь гадаад хүчин зүйлээс шалтгаалсан байна.

3. Дараах 8 арга хэмжээ "эрчимжүүлэх шаардлагатай" үнэлэгдлээ. Үүнд:

- Багийн эмчийн унааг /мотоцикл/ ээлж дараатайгаар шинэчлэх;
- Хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох орон сууцанд хамрагдах хөтөлбөрт эрүүл мэндийн ажилтныг хамруулах;
- Ахмадын сувиллын барилгын ажлыг үргэлжлүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах арга хэмжээний хүрээнд өрхийн суурь судалгаа хийх;
- Газар тариалангийн дунд оврын иж бүрэн трактор нийлүүлэх /Бугат, Шарга, Халиун/;
- Ентүм зочид буудлаас 3, 4 дүгээр байрны хойд талын уулзвар хүртэлх зам, Хийдийн 60 автомашины зогсоол, Жинст баг, Хөгжил хорооллын доод талаас 3, 4 дүгээр гудамжны хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулах;
- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний нэгдсэн систем, уурын зуухны барилгын ажлыг эхлүүлэх /Бугат сум/;
- Сумын төвийн инженерийн шугам сүлжээний холболт, уурын зуухны барилга барих ажлыг эхлүүлэх /Бигэр сум/;

ЗӨВЛӨМЖ

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст:

1. Эрчимжүүлэх шаардлагатай үнэлэгдсэн арга хэмжээг аймгийн Засаг даргын сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ болон агентлагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хангуулах;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС